



# СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК

Монголын МНБИ болон ТМЗН-ийн гишүүн байгууллага

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН “АЙТҮҮЛС” ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр  
тасалбар болгосон санхүүгийн тайлан

Улаанбаатар хот

2025 он

“АЙТҮҮЛС” ХК-ийн товч мэдээлэл.

Албан ёсны хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, 2-р хороолол 34,2 тоот байранд
Хувьцаа эзэмшигчид:	Ай Си Ти Групп ХХК Стандарт Инвестмент ҮЦК ХХК AFC Umbrella FUND-AFC Asia Frontier Бусад
Харилцагч банкууд:	Худалдаа хөгжлийн банк Хас банк Хаан банк Төрийн банк Голомт банк
Аудитын компани:	Сэрэлт Дөл Аудит ХХК
Үйл ажиллагааны зөвшөөрөл:	Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааны 23-2015 дугаарын тусгай зөвшөөрөлтэй бөгөөд 2024 оны 12-р сар хүргэл сунгуулсан.
Албан ёсны хаяг:	УБ хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Сүхбаатарын гудамж, Peace building . 302 тоот



“АЙТҮҮЛС” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот  
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;  
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2025.08.03 № СТА/25-10  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид “АЙТҮҮЛС” ХК-ний 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-д нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЭЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

## Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага (үргэлжлэл)

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

## Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгөхгүй юм.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь Шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- ✓ Санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компанид хамаарах аж

ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлын талаар ярилцсан.

**Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан**

Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрддөггүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасны дагуу “Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК**  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот  
Огноо: 2025 оны 02 сарын 03



**Д.АЛТАНЦЭЦЭГ**  
Захирал, ММНБ

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

<u>Үзүүлэлт</u>	<u>Тодруулга</u>	<u>2023.12.31</u>	<u>Аудитлагдсан 2024.12.31</u>
<b><u>Эргэлтийн хөрөнгө</u></b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	340,709,085.94	418,617,852.50
Дансны авлага	6	1,183,910,966.56	944,378,999.80
Татвар НДШ-ийн авлага			
Бусад авлага	6	36,416,788.53	145,899,678.61
Бусад санхүүгийн хөрөнгө			
Бараа материал	7	144,635,563.48	13,271,760.65
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8	11,413,723.32	25,442,877.64
<b><u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u></b>		<b><u>1,717,086,127.83</u></b>	<b><u>1,547,611,169.20</u></b>
Үндсэн хөрөнгө	9	3,492,122,514.81	3,343,716,770.93
Биет бус хөрөнгө	10	26,148,367.03	19,340,086.27
Урт хугацаат хөрөнгө оруулалт	11	80,446,145.00	80,446,145.00
<b><u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u></b>		<b><u>3,598,717,026.84</u></b>	<b><u>3,443,503,002.20</u></b>
<b><u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u></b>		<b><u>5,315,803,154.67</u></b>	<b><u>4,991,114,171.40</u></b>
Дансны өглөг	12	128,592,870.49	94,937,523.71
Цалингийн өглөг	12		14,951,389.01
Татварын өр	12	62,778,997.91	124,295,865.44
НДШ-ийн өглөг			3,806,821.76
Урьдчилж орсон орлого		114,334,875.22	152,473,047.21
<b><u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u></b>		<b><u>305,706,743.62</u></b>	<b><u>390,464,647.13</u></b>
Урт хугацаат зээл	12	997,000,000.00	238,500,000.00
<b><u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u></b>		<b><u>997,000,000.00</u></b>	<b><u>238,500,000.00</u></b>
<b><u>Нийт өр төлбөрийн дүн</u></b>		<b><u>1,302,706,743.62</u></b>	<b><u>628,964,647.13</u></b>
Хувийн өмч	13	1,481,441,363.28	1,481,441,363.28
Нэмж төлөгдсөн капитал		763,114,860.00	763,114,860.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		460,721,652.19	460,721,652.19
Хуримтлагдсан ашиг		1,307,818,535.58	1,656,871,648.80
<b><u>Эздийн өмчийн дүн</u></b>		<b><u>4,013,096,411.05</u></b>	<b><u>4,362,149,524.27</u></b>
<b><u>ОР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</u></b>		<b><u>5,315,803,154.67</u></b>	<b><u>4,991,114,171.40</u></b>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2023.12.31	Аудитлагдсан 2024.12.31
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	14	<b>3,904,083,856.41</b>	<b>4,424,958,073.35</b>
Борлуулалтын өртөг	15	2,803,346,511.09	2,949,326,466.37
<b>Нийт ашиг /алдагдал/</b>		<b>1,100,737,345.32</b>	<b>1,475,631,606.98</b>
Түрээсийн орлого		35,545,454.56	39,363,636.38
Хүүний орлого		2,335,935.79	13,941,243.15
Ногдол ашгийн орлого			
Бусад орлого	16	24,245.01	4,904,469.06
Борлуулалт, маркетингийн зардал	17	203,683,303.69	221,919,865.50
Ерөнхий ба удирдлагын зардал	17	420,481,664.26	477,463,327.21
Санхүүгийн зардал		239,280,000.00	178,508,480.00
Бусад зардал	18	12,090,558.70	134,309,556.19
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	19	2,730,553.08	-325,976.77
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		681,340.22	-3,713,260.06
Бусад ашиг (алдагдал)			
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>266,519,347.33</b>	<b>517,600,489.84</b>
Орлогын татварын зардал	20	27,860,990.60	65,191,004.62
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>238,658,356.73</b>	<b>452,409,485.22</b>
<b>Орлогын нийт дүн</b>		<b>238,658,356.73</b>	<b>452,409,485.22</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)</b>			

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн	Хөрөнгийн дахин	Хуримтлагдсан ашиг	Дүн
<b>2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,481,441,363.3</b>	<b>763,114,860.0</b>	<b>460,721,652.2</b>	<b>1,069,160,178.9</b>	<b>3,774,438,054.3</b>
Залруулсан үлдэгдэл	1,481,441,363.3	763,114,860.0	460,721,652.2	1,069,160,178.9	3,774,438,054.3
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал				238,658,356.7	238,658,356.7
Өмчид гарсан өөрчлөлт					
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,481,441,363.3</b>	<b>763,114,860.0</b>	<b>460,721,652.2</b>	<b>1,307,818,535.6</b>	<b>4,013,096,411.1</b>
Залруулсан үлдэгдэл	1,481,441,363.3	763,114,860.0	460,721,652.2	1,307,818,535.6	4,013,096,411.1
Тайлант үеийн цэвэр ашиг, (алдагдал)				452,409,485.2	452,409,485.2
Зарласан ногдол ашиг				103,356,372.0	103,356,372.0
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,481,441,363.3</b>	<b>763,114,860.0</b>	<b>460,721,652.2</b>	<b>1,656,871,648.8</b>	<b>4,362,149,524.3</b>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/төгрөгөөр/

<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>2023.12.31</b>	<b>Аудитлагдсан 2024.12.31</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,702,915,006.56</b>	<b>4,306,248,775.33</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,677,188,337.05	4,277,948,513.12
Бусад мөнгөн орлого	25,726,669.51	28,300,262.21
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,345,156,633.57</b>	<b>3,445,412,134.97</b>
Ажиллагчдад төлсөн	565,534,702.94	748,491,940.03
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	164,846,814.45	215,476,900.45
Бараа материал худалдан авахад төлсөн	1,769,774,261.28	1,690,742,841.15
Ашиглалтын зардалд төлсөн	186,578,433.29	183,693,967.59
Түлш, шатахуун, сэлбэг	5,446,594.55	4,560,139.00
Хүүний төлбөрт төлсөн	64,476,000.00	55,714,176.00
Татварын байгууллагад төлсөн	475,940,471.00	430,989,768.64
Даатгалын төлбөрт төлсөн	3,321,860.63	3,669,125.00
Бусад мөнгөн зарлага	109,237,495.43	112,073,277.10
<b>ҮҮАжиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний</b>	<b>357,758,372.99</b>	<b>860,836,640.36</b>
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>136,296,747.85</b>	<b>149,761,243.15</b>
Олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаалт	133,550,832.10	124,920,000.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	410,000.00	10,900,000.00
Хүлээн авсан хүүний орлого	2,335,915.8	13,941,243.15
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>639,737,835.27</b>	<b>738,622,172.40</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	324,589,035.34	537,872,172.40
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,599,000.00	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	10,000,000.00	
Бусдад олгосон зээл урьдчилгаа	299,549,799.93	200,750,000.00
<b>ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(503,441,087.42)</b>	<b>(588,860,929.25)</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>194,806,037.90</b>
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>140,000,000.00</b>
Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		140,000,000.00
Төлсөн ногдол ашиг		54,806,037.90
<b>СҮАжиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(194,806,037.90)</b>
Валютын ханшийн зөрүү	2,921,713.5	739,093.35
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(142,761,000.9)</b>	<b>77,908,766.56</b>
<b>Мөнгө, ба адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>483,470,086.9</b>	<b>340,709,085.94</b>
<b>Мөнгө, ба адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>340,709,085.9</b>	<b>418,617,852.50</b>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

## 1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

“Айтүүлс” ХК (цаашид “Компани” гэх) нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу 2011 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Программ хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр үүсгэн байгуулагдсан.

2012 оноос эхлэн домэйн нэрийн бүртгэл, вэб хост, сервер байршуулалт, виртуал серверийн түрээс, и-мэйл сервисийн ашиглалт зэрэг интернэт мэдээллийн технологийн дэд бүтцэд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст үзүүлж тэдгээрийн аюулгүй байдал, найдвартай, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг 7 хоногийн 24 цагийн турш тасралтгүй хангасаар ирсэн.

“Айтүүлс” ХК-нь 2017 оны 10 сарын 05-нд нээлттэй Хувьцаат компани болсон.

“Айтүүлс” ХК-нь 2020 оны 04 сарын 29-ний 04 тоот ТУЗ-ийн хурлын шийдвэрээр компанийн дүрмэнд шинэчлэл хийж, Компанийн дүрмийн 4.1-дүгээр заалт “Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн үнэ 100/ нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 34,452,124 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэж заасныг “43 /дөчин гурван/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 34,452,124 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэж өөрчлөн, 2020 оны 05 сарын 19-нд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авсан. Уг шинэчилэгдсэн гэрчилгээнд хөрөнгийн хэмжээг 1,481,441.0 мянган төгрөг гэж заасан.

**Компанийн албан ёсны хаяг:** Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол 34-2 тоот байранд гэсэн албан ёсны хаягтай боловч одоо СБДүүрэг 1-р хороо, Реженси резиденс 201 тоот хаяг дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

УБ-ийн гэрчилгээ: 9010001141 тоот

Регистрийн дугаар: 5468361 тоот

Өмчийн хэлбэр: Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүрийн 43 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 34,452,124 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,481,441.3 мянган төгрөг, нэмж төлөгдсөн капитал 763,114.9 төгрөгийн хувьцаатай байна.

Компани нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол Улсад үүсгэн байгуулагдсан, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компани юм.

### Гүйцэтгэх Удирдлага:

№	Овог нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Ч.Мөнхжаргал	“Айтүүлс”ХК-ийн Гүйцэтгэх захирал	0%

**1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ ( Үргэлжлэл)****Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл: ердийн гишүүн**

№	Овог нэр	Гишүүнчлэл	Эзэмшиж буй хувьцааны хувь
	<b>Ердийн гишүүд:</b>		
1	А.Баттамир	ТУЗ-ийн ердийн гишүүн	
2	Д.Бунчинсүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн	
3	Г.Хатанболд	ТУЗ-ийн ердийн гишүүн	
4	Л.Золбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн	
5	Ч.Мөнхжаргал	ТУЗ-ийн ердийн гишүүн	
6	З.Төрболд	ТУЗ-ийн ердийн гишүүн	
	<b>Хараат бус гишүүд:</b>		
7	Г.Гантуяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	
8	Н.Жавхлан	ТУЗ-ийн хараат бус гишүүн	
9	З.Саранчимэг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	

Айтүүлс ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 19-ны өдрийн 24/002 тоот хурлын тогтоолоор ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг дээрх 9 хүний бүрэлдэхүүнтэй сонгосон.

**Нөлөө бүхий Хувьцаа Эзэмшигчид:**

№	Нэр	Тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	Ай Си Ти Групп ХХК	6,131,891.00	17.80%
2	AFC UMBRELLA FUND-AFC ASIA FRONTIER	145,996,000	14.87%
3	Стандарт- Инвестмент ҮЦК ХХК	11,232,506.00	32.60%
	<b>Нийт хувьцааны тоо</b>	<b>22,486,428.00</b>	<b>65.27%</b>

**Тайланг хамарсан хугацаа:** 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс 2024 оны 12 дугаар сарын 31

**2. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ****2.1 Компанийн ногдол ашиг тараах шийдвэр**

“Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн № 24/004 тоот тогтоолоор 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 43/дөчин гурав/ хувь буюу 103,356,372 төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн байна. Нэгж хувьцаа тус бүрд 3/ гурван төгрөг/ төгрөгөөр тооцож ногдол ашгийг хуваарилна. Ногдол ашгийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулж олгосон.